



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 01 өдөр

Дугаар A/17

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, жуулчны
баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, хүчингүй болгох тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5. дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ - Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Шангри-Ла Улаанбаатар хотел ХХК-ний “Шангри-Ла хотел” зочид буудлын 17/059, Эгшиг гранд ХХК-ний “Нью ворлд” зочид буудлын 17/039, Тайёо бридж интернэшнл ХХК-ний “Тайёо” зочид буудлын 16/161, Ногоон туяа ХХК-ний “Ногоон туяа” дэн буудлын 17/029, Моравия ХХК-ний “Шивнээ” дэн буудлын 13/236, Тусанцаг ХХК-ний “Тусанцаг” дэн буудлын 16/174 гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА

D.Batsoy

Д.БАТСҮХ

1117139265
УОА0453 5284325

1150500049

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2018 оны 03 сарын 01 өдрийн Адгуаар тушаалын нэгдүгээр хавсралт

1117139265
УОА0453 5284325

**ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ**

2018.03.01

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Шангри-Ла Улаанбаатар хотел ХХК	5149037	Шангри-Ла хотел	СБД-ийн 1-р хороо Олимпийн гудамж 19
2	Бишрэлт ХХК	5508509	Бишрэлт	ЧД-ийн 4-р хороо Самбуугийн гуламж 43
3	Эгшиг гранд ХХК	5450098	Нью ворлд	СБД-ийн 10-р хороо цагдаагийн гудамж 31
4	Болор цэн ХХК	2776235	Эрч	СХД-ийн 18-р хороо Энхтайвны өргөн чөлөө 137б
5	Тайёо бридж интернэшнл ХХК	5284244	Тайёо	БЗД-ийн 18-р хороо Дамдинсүрэнгийн гудамж 47

--ооОоо--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 03 сарын 01
өдрийн А(7) дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.03.01

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ногоон туяа ХХК	5669782	Ногоон туяа	СХД-ийн 27-р хороо Толгойтын 10
2	Мөнх хөхий ХХК	2833158	Уянга	БЗД-ийн 16-р хороо Да хүрээ гудамж 57-1
3	Сод айгар ХХК	5369495	Болор	СХД-ийн 6-р хороо тоосгоны 3-20 тоот
4	Моравия ХХК	5058562	Шивнээс	СХД-ийн 19-р хороо үйлдвэрчний эвлэлийн гудамж 102
5	Тусанцаг ХХК	5066409	Тусанцаг	ЧД-ийн 40 мянгатын 11-2 тоот

--ooOoo--